



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 12 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 481

Улаанбаатар
хот

Төрийн болон орон нутгийн өмчийн талаар
авах зарим арга хэмжээний тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

► 1. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын дүнгийн мөрөөр дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, холбогдох албан тушаалтанд даалгасугай:

1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн эрхийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэхтэй холбогдох журмын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т;

1.2. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг баталгаажуулах, цахим бүртгэлд бүрэн хамруулах, газрыг үнэлж, санхүүгийн тайланд тусгах ажлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар (А.Энхманлай)-т тус тус;

► 1.3. Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийг автотээврийн хэрэгслийн бүртгэлтэй тулган баталгаажуулж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар арга хэмжээ авч ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), төсвийн ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, "Автотээврийн үндэсний төв" УТҮГ-т;

1.4. Төрийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг шийдвэрлүүлэх тухай бүрд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт мэдэгдэж, өмчийн өөрчлөлт, хөдөлгөөнийг төрийн өмчийн бүртгэлд тусгуулж байхыг Засгийн газрын гишүүдэд;

1.5. Улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламж болон гадаад зээлийн хөрөнгийн дамжуулан зээлдүүлэх зээлийн эх үүсвэрээс бий болсон хөрөнгийг хууль тогтоомж болон эрх бүхий этгээдийн шийдвэрийн дагуу ашиглах, эзэмших төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн ашиглалтад хүлээн авч, данс бүртгэлд нь тусгуулах арга хэмжээ авч ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), төсвийн ерөнхийлөн захирагч нарт;

1.6. Концессын гэрээний дагуу төрийн өмчид шилжиж буй хөрөнгийг хүлээн авч тооцоо нийлэх, эзэмших, ашиглах хуулийн этгээд, байгууллагын данс бүртгэлд тусгуулах асуудлыг тухай бүр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлж байхыг Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатарт;

- 1.7. Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн бүртгэлийг сайжруулах арга хэмжээ авч ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт;

1.8. Үйл ажиллагаа нь доголдсон, зогсонги байдалд орсон, хувийн хэвшилтэй давхардсан үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, үйлдвэрийн газрыг татан буулгах, өөрчлөн байгуулах зэргээр бүтцийн өөрчлөлт хийх, хөрөнгийг нь шилжүүлэх, худалдах ажлыг зохион байгуулах санал боловсруулж танилцуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т;

- 1.9. Улсын үзлэг, тооллогын дүнгээр дутагдсан хөрөнгийг нөхөн төлүүлэх, хэрэгцээнээс илүүдэлтэй болон цаашид ашиглах боломжгүй болсон хөрөнгийг шилжүүлэх, худалдах, устгах, өмчлөлийн талаар маргаантай байгаа хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг холбогдох яам, агентлагтай хамтран зохих журмын дагуу авч хэрэгжүүлж, нэгдсэн дунг 2023 онд багтаан Засгийн газарт тайлагнахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд үүрэг болгосугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Д.АМАРБАЯСГАЛАН